

Хаант улсын цаазын газар Гехенна



Өмнөх нийтлэлд бид Есүсийн их ярьсан “там” буюу - зөв орчуулахад - “Гехенна” Иерусалим хотын баруун өмнөд талд орших нарийхан “Хинномын хөндий” болохыг мэдсэн. Тэр хөндийд иудейчүүд «Хуучин



Кэнааны шүтээнийг
үрсээрээ тахиж
Газар нутгийг тэд цусаар
бузарлажээ...

Дуулал 106:38

гэрээ»-ний үед үр хүүхдээ Молех гэдэг харийн бурханд зориулж өргөл болгон шатаадаг байсан билээ. Доод ертөнцийн хаан болохын хувьд тийм тахил шаардсан Молех үнэн “тамын бурхан” мөн.

Бүтээгч Эзэн энэ хэргийг ихэд зэвүүцэн жигшин, санаанд оромгүй аймшигтай гэж тодорхой буруутгасан юм. Тийм боловч

Христигэлийнхэн яг тэр хөндийг Бүтээгч Эзэн ихэнх бүтээлээ мөнхөд тамлах тамыг хэлдэг гэсэн ойлголттой явдаг! Тийм үзэлтэй хүн Хайрын их Эзэнийг Молехтой адилтгадаг гэхэд хэтрүүлээгүй хэрэг.



Хаант улсын цаазын газар Гехенна □ 2

Библийн орчуулга тэр хөндийн нэрийг “Гехенна” гэж галиглахгүйгээр “там” юмуу “мөнхийн зовлон” гэж болгодог учраас зөв ойлголт авах нь мэдээж хэцүү. Тийм ч учраас итгэгч хүмүүс өөрсдөө Библийг судлах хоорондоо хуваалцаж ярилцах нь чухал.

Гехенна ямар ч байсан шийтгэлийн газар мөн болох нь тодорхой. Харин тэр шийтгэл мөнхийн зовлонт тамыг хэлээгүй бол Есүсийн тэр талаар хэлсэн үг ямар учиртай вэ?

Гехенна айсуй Хаант улстай холбоотой

Хажуу дахь шигтгээг судалвал «Матай» номд

Гехеннагийн тухай хамгийн олон (6 удаа) гардаг нь сонирхол татна. «Матай» бол онцгойлон иудейчүүдэд зориулж Есүсийн хийсэн үйл, ярьсан үгийг бичсэн тэмдэглэл юм. Үүнээс гадна «Матай» Түүнийг еврейчүүдэд амласан Хаант улсын Хаан болохыг харуулдаг.

Есүсийн Гехенна тухай ярьсан 11 ишлэлүүд:
-Матай 5:22, 5:29-30,
10:28, 18:9, 23:15,
23:33
-Марк 9:43, 9:45, 9:47
-Лук 12:5

Тийм ч учраас Есүс ирээдүйн тэр Хаант улсынхаа тухай «Матай»-д хамгийн их ярьсан. Матайгийн онцгой нэр томъёо нь “Тэнгэрийн хаанчлал”. “Хаанчлал” гэж орчуулсан грек үг бас “хаант улс” гэсэн утгатай. “Тэнгэрийн”





гэсэн тодорхойлолт нь тус хаант улсын байгуулах газрыг хэлээгүй, харин үүсэл гарал ба тэнгэрлэг мөн чанарыг нь заана.¹

«Лук» болохоор Есүсийг ялангуяа Төгс Хүн (“Хүний Хүү” буюу “Адамын Хүү”) болохыг харуулсан.

Тиймээс ч Лук тэмдэглэлээ Адамаас гаралтай бүх хүмүүст зориулж бичсэн бөгөөд Гехеннаг ганцхан удаа л дурдсан байна.

Одоо Гехеннаг дурдсан бүх ишлэлийг хам сэдвээр нь нарийвчлан авч үзье. Эхний хоёр ишлэл нь ирээдүйн мянган жилт “Тэнгэрийн хаанчлал”-д хэрэгжих Хуулийг дэлгэрэнгүй танилцуулдаг, Есүсийн “Уулан дээрх номлол”-д багтдаг (Матай 5-7). Гехеннагийн тухай сэрэмжлүүлсэн үгээ Есүс юун түрүүнд Өөрийн дагалдагч нартаа хандаж хэлсэн байдгийг анхаарна уу!

1 Вавилон улсын хааны зүүдэнд тус хаант улс ирэх тухай зөгнөсөн бий. Үүнд: “...хүний гараар цавчигдаагүй нэгэн чулуу” хүн төрөлхтөний байгуулсан, дэлхийг хамарсан хэдэн хаант улсыг бэлэгдэх хөшөөг “хэмх цохиод бутаргаж” орхиод... бүгд “ор мөргүй алга болов. Харин хөшөөг цохиосон өнөөх чулуу аварга том уул болж, хамаг дэлхийг дүүргэжээ...”

Тэнгэрийн Бурхан хэзээ ч устгагдашгүй, өрөөл бусдын гарт оршгүй нэгэн хаант улсыг тогтооно. Энэ хаант улс нь дээрх бүх хаант улсыг бутаргаж, харин өөрөө мөнхөд тогтоно. Нэгэн чулуу хүний гар хүрэлгүйгээр уулаас цавчигдаж, төмөр, хүрэл, шавар, мөнгө, алтан хэсгүүдийг бутаргахыг та харсан нь ийм учиртай билээ...” (Даниел 2:34-35, 44, СМО).

“Тэнгэрийн доорх хаант улсуудын хаанчлал, ноёрхол, сүр хүч нь Дээдийн Дээд Бурханы ариун хүмүүст өгөгдөнө. Хаанчлал нь үүрдийн хаанчлал байх бөгөөд ноёрхол бүр Түүнд мөргөж, Түүнд үйлчлэх болно” (Даниел 7:27).



Энэ баримтаас эхний дүгнэлт гаргахад Гехеннагийн шийтгэл ирээдүйн Хаант улстай холбоотой бөгөөд ялангуяа иудейчүүдэд хамаатай байх бололтой.

Гехеннагийн шийтгэл нь хэрэгт таарах хэмжээтэй

Матай 5:20-22. “Би та нарт хэлье, хэрэв та нарын зөвт байдал чинь фарисайчууд болон хуулийн багш нараас илүү гарахгүй л бол, та нар тэнгэрийн хаанчлалд орохгүй. “Хүн алж болохгүй, хүний амийг хөнөөсөн хэн боловч шийтгүүлбэл зохино” гэж эртний хүмүүст айлдсаныг та нар сонссон. Харин Би та нарт хэлье, ах дүүдээ хилэгнэгч алив хүн шүүхийн өмнө буруутай. Ах дүүгээ “Хоосон толгой” гэж хэлсэн хэн боловч зөвлөлийн өмнө буруутай. “Мунхаг” гэж хэлсэн хэн боловч галтай тамд [=Гехеннад] орохоор хангалттай буруутгагдах болно.”



Аливаа үг Библид анх удаа дурдагдахдаа маш чухал зүйлийг бидэнд зааж чаддаг гэсэн зарчим бий. Гехенна гэдэг үгийн хувьд яг тийм. Есүс Гехеннагийн шийтгэлийг дээрх ишлэлд анх дурдахдаа “эртний



хүмүүст айлдсан” Мосегийн Хуультай холбодог.

Мосегийн Хуулийн дагуу:

“...амийг амиар, нүдийг нүдээр, шүдийг шүдээр, гарыг гараар, хөлийг хөлөөр, түлэгдэлтийг түлэгдэлтээр, шархыг шархаар, бэртэнгийг бэртэнгээр төлнө”

(Египетээс гарсан нь 21:23-25, Матай 5:38). Гэм болгон таарч тохирсон, шударга шийтгэл хүртэх ёстойг энэ Хуулийн шаардсан

бөгөөд энэ нь зөв болохыг Есүс баталсан (Матай 5:17-19). Тэгвэл “Гехенна”-д орох шийтгэл ч гэсэн хэмжигдэхүйц буюу хязгаарлагдмал чанартай байх ёстой.



Та хүнд “мангар” гэж дуудуулж гомдож үзсэн бол хэсэг хугацааны дараа тийм хэргийг хүн тоохоо больдог гэдгийг ч мэднэ. Тиймэрхүү үг хэнд ч мөнхийн зовиур болохгүй. Тэгвэл ах дүүсээ “мунхаг” гэж доромжилсон хүнд хэзээ ч дуусахгүй шийтгэл тохоох нь хийсэн хэрэгт тохирохгүй, хамаагүй хэтрүүлсэн хэрэг болох нь ойлгомжтой биз ээ. Үүнээс гадна, төгсөшгүй шийтгэлийг хэрхэн хэмжих билээ? Боломжгүй хэрэг!

Их Эзэн ард түмнийхэндээ оноодог шийтгэлийг хэмждэг бөгөөд Түүний хэрэглэдэг хэмжүүрийн жишиг бол тэдний бусдыг шүүсэн хэмжүүр (Матай 7:2). Гехенна ч гэсэн хийсэн хэрэгт тааруулсан шийтгэл юм.



Гехеннад махбод ч, сэтгэл ч устгагдах боломжтой

Матай 5:28-30. “Хэрэв баруун нүд чинь чамайг бүдрүүлбэл, ухаж аваад хая. Учир нь чиний бүтэн бие тамд [=Гехеннад] хаягдсанаас биеийн чинь нэг эрхтэн байхгүй байх нь чамд дээр. Хэрэв баруун гар чинь чамайг бүдрүүлбэл, тастаж хая. Учир нь чиний бүтэн бие тамд [=Гехеннад] хаягдсанаас биеийн чинь нэг эрхтэн байхгүй байх нь чамд дээр.”

Хүний “бүтэн бие” “там”-д буюу Гехеннад хаягдах тухай дурдсаныг анхаарна уу. “Там бол үхлийн дараа очдог биегүй сүнснүүдийн зовдог газар” гэсэн ойлголтонд Есүсийн энэ үг бас нийцэхгүй. Дараагийн ишлэл “бүтэн бие”-ийг “махан бие” мөн болохыг батална. Дээр нь сэтгэлийг дурдсан байна. Гэтэл сэтгэл “тамд” тамлагдах биш, Гехеннад “устгагдана” гэсэн. Үүнд:

Матай 10:28. “Биеийг хөнөөх хүмүүсээс бүү ай. Учир нь тэд сэтгэлийг хөнөөж үл чадна. Харин махан бие болоод сэтгэлийг, хоёуланг нь тамд [=Гехеннад] устгаж чадах Түүнээс айгтун.”

Лук 12:4-5. “Би та нарт хэлье. Андууд минь, биеийг хөнөөгсдөөс бүү ай. Хөнөөсний дараа тэд яаж ч чадахгүй. Харин хэнээс айж эмээвэл зохихыг та нарт сануулъя. Хөнөөсний дараа тамд [=Гехеннад] хаях эрх мэдэлтэй Нэгэнээс айж эмээгтүн. Тийм ээ, Би та нарт хэлье, Түүнээс айгтун.” (Матай 10:28-д өгсөн тайлбарыг үзнэ үү.)



Дайсагнах хүмүүсийн “бие хөнөөх” үйлдэл нь жирийн аллага болох нь ойлгомжтой. Мэдээж хүн үхэхдээ сэтгэл нь мөн адил үгүй болдог.² Гэтэл биеийг хөнөөсөн хүмүүс “дараа нь” яаж ч чадахгүй, тухайлбал “сэтгэлийг хөнөөж чадахгүй”. Энэ нь “сэтгэл”-ийг энд тусгай утгатай болохыг харуулна. Гэвч хүмүүсийн хийж чадахгүй зүйлийг хийж чаддаг Нэгэн бий. Тэр бол мэдээж Их Эзэн Өөрөө. Тэрээр “хөнөөсний дараа” ч махан бие ч, сэтгэлийг ч Гехеннад устгаж чадна гэнэ. Энэ үг ямар учиртай вэ? Энэ хачирхалтай ишлэлийн эргэн тойрны хам сэдвийг харахад Есүс дагалдагч нартаа Өөрийнх нь ирэхээс өмнөхөн үед хийх зүйлийг зааж байсан. Үүнд:


“Тэнгэрийн хаанчлал ойрхон байна” гэж тунхаглагтун... Миний нэрээс болж бүгд та нарыг үзэн ядна. Харин эцсээ хүртэл тэссэн нь аврагдах болно... Загалмайгаа үүрээд Миний хойноос дагахгүй хүн Миний хувьд зохистой нэгэн биш. Амиа [грек: Сэтгэлээ] ологч нь түүнийгээ алдах болно. Миний төлөө амиа [грек: сэтгэлээ] алдсан нь түүнийгээ олох болно...” (Матай 10:7, 22-23, 38-39).

Энэ бүх үгээ Есүс гарцаагүй иудей дагалдагч нартаа – андууддаа - хэлснийг дахин анхааръя. Сэтгэл бол хүний өөрийн оршин буйгаа мэдээд, юм харж, сонсож, мэдэрч, үнэрлэж, бодож сэтгэх мөн хүсэх “мэдээ мэдрэхүйн төв” юм. Иймд “сэтгэл” гэдэг нь дан “амь”

2 Дэлгэрэнгүй тайлбар авахын тулд “Хүн бол амьд сэтгэл” гэсэн судалгааг маань үзнэ үү.



гэснээс илүү сэтгэлийн хүсэл болох бие сэтгэлийн жаргалыг хэлнэ. “Сэтгэлээ ологч” хүн энэ амьдралд жаргаж байхад “сэтгэлээ алдсан” нь тав тухаа, бие сэтгэлийн жаргалыг алдаж, оронд нь ичгүүр гутамшиг, бие сэтгэлийн зовлонг тээх бөгөөд амиа хүртэл алдаж болно.



Еврейчүүдэд амласан амгалант Хаант улс бол Нацагдоржийн үгийг зээлэхэд, “Мянган жаргалын үүд”. Төгс эрүүл энх явах жаргалаас гадна бие сэтгэлийн сая сая “жаргалан, жаргалан, жаргалан, энэ ертөнцийн түмэн жаргалан” тэнд хүлээнэ. Шинэчлэгдсэн тэр дэлхийд амьдрах чухам амьдралыг иудейчүүд “мөнхийн амьдрал” гэдэг.³

Тиймээс ч еврей хүн бүр заавал тэр Хаант улсад орохыг мөрөөднө. “Сэтгэл” гэдэг үг нь хүслэн болсон тэр бүх жаргалыг төлөөлнө. Гэтэл өнөөгийн амьдралдаа Христийн загалмайг үл ойшоон жаргаж явахыг илүүд үздэг хүн ирээдүйн тэр мянган жилийн жаргалыг амсах ч үгүй. Харин энэ

3 Библийн “мөнх” гэж орчуулдаг грек үг “эон” нь “төгсгөл нь харагдахгүй урт удаан үе” гэсэн утгатай. Мөнх гэсэн үгийн тухай цуврал судалгааг үзнэ үү.



амьдралдаа Христийг илүүд үзээд дагасан хүмүүс одоо хэцүү явсан ч тэр жаргалыг зайлшгүй хүртэх болно. Хэрэв Христийг дагасныхаа төлөө алуулсан ч хэн ч түүнийг дахин амилж, тэр тусмаа Хаант улсад жаргахаас болиулж чадахгүй.



Гэтэл тэр хаанчлал туйлын шударга болохоор (Еврей 1:8) дагалдагч Хаант улсад орсон ч гэсэн тэндээ гэмт хэрэг үйлдвэл зайлшгүй шүүгдэх болохыг Есүс анхааруулжээ. Их Хаан Гехеннагийн шийтгэлийг оноовол тэр хүн үхэж, бие сэтгэлийн тэр үлэмж их жаргалаас хасагдана.

Үүнээс харахад Их Эзэний төлөвлөгөөний дагуу гэм ба үхэл Тэнгэрийн хаант улсад бүрэн арилж амжаагүй байх болно.



Гехеннад буй өт хорхой үхэхгүй, гал нь унтрахгүй...

Матай 18:8-9. “Хэрэв гар чинь, эсвэл хөл чинь чамайг бүдрүүлбэл, тас цавчин хая. Хоёр гартайгаа, эсвэл хоёр хөлтэйгөө мөнхийн [=эоний үеэр үргэлжлэх] галд хаягдсанаас гаргүй, эсвэл хөлгүйгээр аминд орох нь чамд дээр. Хэрэв нүд чинь чамайг бүдрүүлбэл, ухаж хая. Хоёр нүдтэйгээр галт тамд [=Гехеннад] хаягдсанаас нэг нүдтэй аминд орох нь чамд дээр.”

Марк 9:43-47. “Хэрэв гар чинь чамайг бүдрүүлбэл тастаж хая. Унтаршгүй галтай тамд [=Гехеннад] хоёр гартай очсоноос аминд тахир дутуу орох нь чиний хувьд дээр юм. [Тэнд өт хорхой нь үхэхгүй. Гал нь унтрахгүй.] Хэрэв хөл чинь чамайг бүдрүүлбэл тастаж хая. Тамд [=Гехеннад] хоёр хөлтэй хаягдсанаас аминд доголон орох нь чиний хувьд дээр юм. [Тэнд өт хорхой нь үхэхгүй. Гал нь унтрахгүй.] Хэрэв нүд чинь чамайг бүдрүүлбэл ухаж хая. Тамд [=Гехеннад] хоёр нүдтэй хаягдсанаас Бурханы хаанчлалд өрөөсөн нүдтэй орох нь чиний хувьд дээр. Тэнд өт хорхой нь үхэхгүй. Гал нь унтрахгүй.”





“Хорхой нь үхэхгүй, гал нь унтрахгүй” гэсэн хэллэг «Хуучин Гэрээ»-ээс татсан иш. Есүс Гехеннаг Исаиагийн энэ ишлэлтэй холбосон нь утгыг нь тодорхой болгож өгдөг. Үүнд:

Исаиа 66:23-24 (СМО). "Шинэ сарын баяраас Шинэ сарын баяр хүртэл, Нэг Амралтын өдрөөс нөгөө Амралтын өдрийг болтол Махбодот бүхэн Намайг хүндэтгэн дээдлэхээр Миний өмнө хүрч ирнэ" гэж ИАВЭ айлдаж байна.

“Харин тэд гадагш гарч явахдаа, Надтай тэрсэлдэгчдийн хүүрийг үзнэ. *Тэднийг идэх өт хорхой нь үхэхгүй. Тэднийг шатаах гал нь унтрахгүй.* Тийнхүү бүх махбодод жигшил болно”.



Исаиагийн бичсэн энэ сүүлчийн бүлгийг уншихаар Их Эзэний баригдах Өргөө (1-р иш), Израйлийн үнэнч ард түмэн ганц өдрийн дотор шинээр төрөх (8-р иш), Иерусалим хот амар тайван болох (12-р иш), Их Эзэн өстөн дайснууддаа уураа үзүүлж тэднийг шийтгэх (14-р иш), бүх үндэстнийг цуглуулж алдраа үзүүлэх (18-р иш), бүгд товлосон цагт нь Их Эзэнд хүндэтгэл үзүүлэхээр Иерусалим хотод ирэх (23-р



иш), Түүнтэй тэрсэлсэн хүн хэрхэн шийтгүүлснийг бүгд харах зэрэг сэдэв орсон. Та өөрөө нэг уншаад үзээрэй.

Ингээд Гехенна шинээр байгуулагдах Хаант улсад явагдах шийтгэлийн газар болох нь батлагдсан. Мөнхийн Эзэнийг хүндэтгэх албан ёсны газар бол Иерусалим дэх Өргөө болохыг бид мэднэ (20-р иш).⁴ Одоогийн байдлаар Иерусалимд Их Эзэний Өргөө байхгүй ч гэсэн мянган жилийн Хаант улсыг эхлэхэд тэнд сүрлэг шинэ Өргөө байгуулагдахыг бид эш үзүүлэгч Езекиелээс мэднэ (40-48-р бүлэгт). Тэгэхээр “үхэхгүй хорхой”, “унтрахгүй гал”-аар тодорхойлох Гехенна буюу “Хинномын хөндий” Иерусалимын ойролцоо орших газар хэвээр.

Исаиа мөн Хаант улсын тухай зөгнөхдөө: “Хожим хойно ИАВЭгийн Өргөө буй уул нь Уул уулсын тэргүн болно... Тэр л уул рүү үндэстнүүд бүгдээрээ урсгал усан мэт түрэн ирнэ. Ард түмнүүд олноороо ирээд “Нааш ир, ИАВЭгийн уул руу явцгаая. Иаковын Бурханы Өргөөнд очицгооё. Зам мөрөө Тэрбээр зааж сургана. Жим юугаар нь тэгээд бид алхана” гэнэ. Заавар чиглүүлэг нь Ционоос гарна. ИАВЭгийн үг Иерусалимаас гарна. Үндсэтнүүдийн хоорондхыг Тэрбээр шүүж Олон ард түмний маргааныг шийдвэрлэнэ...” (Исаиа 2:2-4).

4 Дэд хууль 12:5-6, 10-11; 2 Самуел 7:1, 10-13; 1 Хаад 5:16-19; 2 Шастир 7:12; 33:4 “Иерусалимд Би алдар нэрээ эгнэгт [=эоний үеийн турш] байлгах болно” гэж ИАВЭ алдсан билээ (СМО).



Янз бүрийн үндэстнээс Их Эзэнийг хүндэтгэхээр ирсэн хүмүүс Иерусалим хотын гадаа гарахдаа Гехенна хөндийг харах боломжтой. Тэнд Их Эзэний эсрэг боссон гэмт хэрэгтний цаазаар авахуулсан хүүрийг галд шатаж байхыг харна.

Энэ бүхэн Гехенна хөндийн тухай мэдсэн бас нэгэн зүйлийг санаанд оруулна. Тус хөндий олон хүүрээр дүүргэх учраас “Аллагын гуу” эсвэл “Хядлагын хөндий” гэж нэрлэгдэх болохыг Их Эзэн иудейчүүдэд хэлүүлсэн (Иеремиа 7:31-33). Энэ нь өнгөрсөнд тодорхой хэмжээгээр биелсэн ч ирээдүйд бүрэн биелэгдэх болно.

Дахин анзаарахад, энэ шийтгэл бол энэ дэлхий дээр амьд яваа зарим хүнд л тохиолдох явдал. Тэд жигшүүртэй хэрэг хийсний улмаас үхэх ял авч Хаант улсын жаргалаас хасагдан оршуулагдах хүндэтгэлийг ч хүртэхгүй. Энэ бол монголчуудын “там” гэдэг төсөөллөөс алс хол буй бодит байдал юм.

Тэгвэл галд тэсвэртэй, мөнхийн амьтай гэмээр тэр өт хорхой ямар учиртай вэ? Энэ талаар олон хүн гайхаад, тэр өтөөр идүүлж буй хүн нь ч адилхан мөнхийн зовлонт амьтай гэж боддог. Гэтэл эдгээр хорхой амьд нэгнийг биш, гэмт хэрэгтний цогцос хүүр буюу амьгүй биеийг идэхийг Исаиа шууд хэлсэн. Амьгүй бие юу ч мэдэрч чаддаггүйг хэн ч мэдэх учраас нэгэнт нас барсан тэр хүмүүс өвдөлт зовлон мэдрэхээ больсон нь эргэлзээгүй.



Энэхүү “тамд” тэгвэл орилдог хүмүүс биш, дуугүй цогцос л байна. Өт хорхой нь хүртэл “үхэхгүй” биш, грек эхэнд “дуусахгүй” гэж байгаа. Үхсэн өт хорхойг өөр олон өт орлоход идэх юм л байхад өт хорхой ч байх болно гэсэн үг. Энэ юуг харуулж буй гэвэл, тэрслүү хүн хэрхэн эцэслэхийг хүмүүс нүдээрээ харж чадсан ч тэрслүү хүмүүс даанч гарсаар л байх болно. Хаант улсын туйлын шударга Хаан хүмүүсийн хийсэн үйлс ба яагаад хийсэн сэдлийг нь нарийн мэддэг учраас шүүлтээ хугацаа алдалгүйгээр гүйцэтгэх болно.

Үүний жишээ Ананиа, Сапфир хоёрын түүх юм (Үйлс 5). Тэд шуналтайдаа Их Эзэнийг хуурч Түүнд худал хэлснийг Петр шууд л мэдсэн. Хийсэн хэргийг нь хэлж өгөхөд хоёулаа тэр дороо газар унаж



амьсгаа хураав. Хаант улсын шийтгэл тийм шуурхай байх болно.

Олон хүн даанч ийм

шударга шүүлтийн ачаар засагдахгүй болохыг мянган жилийн эцэст гарах том бослого нотолно (Илчлэл 20:7-10). Иймд Гехеннагийн гал унтрахгүйд



гайхах зүйл алга. Шатахуун л байх үед гал унтрахгүй нь ойлгомжтой.

Гехеннагийн галыг “мөнхийн” чанартай гэж бичсэн нь тийм учиртай. Юу гэвэл, тэр гал Хаант улсын эон үеийн турш буюу мянган жилийн хугацаанд дүрэлзсээр байх болно.⁵

Харин үүний дараа энэ дэлхий дэлбэрч, галаар шатан оршихоо болих учраас Гехенна гэдэг газар ч мөн адил оршихоо болино (2 Петр 3:10; Илчлэл 20:11). Шинэ дэлхий дээр үхэл байхгүй учраас Гехеннагийн үйл ажиллагаа гарцаагүй төгсөх тавилантай (Илчлэл 21:4). Үүнээс ч харахад Гехенна мөнхийн мөнхөд үргэлжлэх тамын газар байх боломжгүй.

“Гехеннагийн шийтгэл” бол Хаант улсын жаргалаас хасагдахын хэлнэ

Матай 23:15. “Хоёр нүүрт хуулийн багш нар, фарисайчууд та нар золгүй еэ! Юу гэвэл, та нар ганц хүнийг ч гэсэн сүсэгтнээ болгохын тулд тэнгис газаргүй хөндлөн гулд явдаг. Түүнийг сүсэгтэн болоход та нар түүнийг өөрсдөөсөө хоёр дахин дор тамын [Гехеннагийн] хүү болгодог ажээ.”

5 Библийн “мөнх” гэж орчуулдаг грек үг “эон” нь “төгсгөл нь харагдахгүй ч хэзээ ч нэгэн цагт дуусах урт удаан үе” гэсэн утгатай. Мөнх гэсэн үгийн тухай цуврал судалгааг үзнэ үү.



Матай 23:33. “Могойнууд аа, хорт могойн удам аа, тамын [=Гехеннагийн] шийтгэлээс та нар яаж зугтаах вэ?”

Есүс фарисайчуудыг “Гехеннагийн шийтгэлээс” мултрахгүй “Гехеннагийн хүү” гэж хэлсэн (мөн Матай 5:20-г үзнэ үү). “Гехеннагийн хүү” гэсэн еврей маягийн хэллэг тэрхүү шийтгэл хүртэх зохилтой хүнийг хэлнэ.⁶ Есүсийн дайсан болох фарисайчууд



угаасаа Хаант улсад орохгүй учраас тэнд цаазлагдах нь аргагүй. Есүс тэднийг Гехеннад хаягдан орохыг ч хэлээгүй, харин Гехеннад орвол таарна гэсэн. Есүс үгээ их нарийн сонгодог байсан нь ахин харагдаж байна. “Гехеннагийн шийтгэл” тэгвэл эхнээс нь “Хаант улсын жаргалаас хасагдах” шийтгэлийг хэлсэн шилжсэн утгатай үг болж таарна.

6 Үүнтэй ижилхэн бүтэцтэй “үхлийн хүү” гэсэн хэллэг 1 Самуел 26:16-н еврей эхэнд бий. АБ утгыг нь “үхвэл зохилтой” гэж орчуулдаг. Есүс Иудасыг “мөхлийн хүү” гэж нэрлэсэн нь бас тийм төрлийн хэллэг (Иохан 17:12). 2 Тесалоник 2:3-т гардаг “сүйрлийн хөвгүүн” нь мөхөх тавилантай эцсийн Антихристийг хэлнэ.



Дүгнэж хэлэхэд, энэ дэлхий дээр удахгүй байгуулагдах Тэнгэрийн хаанчлалын эхний мянган жил үнэхээр жаргалтай байсан ч гэм ба үхэл дэлхийд байгаа хэвээр байх болно. Иймд тэр мянган жилийн турш шударга ёс ноёрхохдоо хийсэн гэмт хэрэг бүрд таарч тохирсон шийтгэл оноогдох болно. Хааны нийслэл болох Иерусалимын гадаа байх цаазын газрыг Гехенна гэдэг. Дээд ял хүртэж үхэж унасан гэмт хэрэгтний хүүрийг Гехеннад хаяж, шатаадаг байх болно. Өт хорхой, шатан дүрэлзэх гал тэдгээр цогцосыг идэж, устгах бодит үүрэгтэй. Гехеннагийн үйл ажиллагаа мянган жилийн эон үеийн турш явагдах болно. Энэ бүхнээс харахад Гехенна бол яав ч мөнхийн зовлонт тамын газар биш.

Энэ бүхнийг мэдэж авсан та Гехеннагийн тухай дээрх 11 ишлэлийг дахин цоо шинэ нүдээр уншиж үзээд дээрх шинэ ойлголтууд таарах эсэхийг нь шалгаарай. □

Дараагийн нийтлэлдээ бид мөнхийн зовлонт тамыг Библийн өөр хэллэгээс эрж хайх болно.



Ашигласан эх сурвалж

---Ариун Библи (2004; 2013; 2019). Улаанбаатар: Ариун Бичээс Нийгэмлэг. Энэ судалгаанд АБ гэж товчилсон.

---Библи (2015). Улаанбаатар : Монголын Библийн Нийгэмлэг. Энэ судалгаанд ББ гэж товчилсон.

---Стандарт Монгол Орчуулгын апп (2023). Энэ судалгаанд СМО гэж товчилсон.

---Strong, J. (1890). Strong's exhaustive concordance of the Bible (with Greek and Hebrew Lexicons). www.blueletterbible.org